



Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<ul style="list-style-type: none"> - Бодь даатгал ХК - Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 000215799 - Үнэт цаасны код - Утасны дугаар 75054800
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	- “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	- Тусгай зөвшөөрөлд бичигдсэн даатгалын үйлчилгээ эрхлэх
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	- 235,319,718 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн – Ерөнхий нягтлан бодогч Э.Энхцэцэг</p> <p>Бэлтгэсэн – Актуарч Н.Цэрэнлонжид</p> <p>Хянасан – Үйл ажиллагаа хариуцсан захирал М.Мөнхбаатар</p>

1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хавсралт№1
	Орлогын тайлан	Хавсралт№2
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Хавсралт№3
	Мөнгөн гүйлгээний тайлан	Хавсралт№4

2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцээж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>	
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>	
3.1	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<i>Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ - 0.05% Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE – 0.15%</i>
3.2	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	<i>Хохирлын харьцаа: 52.4% Зардлын харьцаа: 50.0% Хосолсон харьцаа: 102.5% Үйл ажиллагааны харьцаа: 99.2% Дүрмийн сан / хураамжийн нийт орлого: 24.8% Дүрмийн сан / нөөц сан: 97.4% Дүрмийн сан / нөхөн төлбөр: 44.9% Төлбөрийн чадварын харьцаа – 110.36%</i>
3.3	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<i>Компанийн зүгээс нөхөн төлбөрийн зардлыг бууруулах зорилгоор бүтээгдэхүүний багцыг солонгоруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Хохирол багатай бүтээгдэхүүний нийт багцад эзлэх хувийн жинг нэмэгдүүлэн ажиллаж байна.</i>
3.4	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн аливаа ажил гүйлгээ байхгүй болно.</i>
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	<i>ТУЗ-н 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 23/15 тоот “Үл хөдлөх хөрөнгө бүртгэн авах зөвшөөрөл олгох тухай” -д заасаны дагуу Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Дэндийн ам гудамж, 10 тоот хаягт орших гэрчилгээний 000461870 дугаартай, Ү-2204019513 тоот улсын бүртгэлийн дугаартай 201.5 мкв талбай бүхий аж ахуйн зориулалттай үл хөдлөх хөрөнгө.</i>	
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалтын тайлан, мэдээлэл</i>	
<i>2023 оны 3 дугаар улирлын байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.</i>		
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	

	<p>2023 оны 04 дүгээр сарын 25-д Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулан Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н гаргасан дүгнэлтийг батлан, Компанийн ТУЗ-н ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, Компанийн ТУЗ-н үйл ажиллагааны зардлыг баталсан ба 3-р улирлын байдлаар Нэр дэвшүүлэх хороо нь 2 удаа, ТУЗ-нь 5 удаа хуралдаж тогтоол шийдвэр гарган ажиллаж байна. Үүнд 2023 оны 06 дугаар сарын 29 –ний өдрийн 23/14 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал өөрийн хүсэлтээр ажлаас гарах хүсэлт өгсөн ба Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг цуцлах тогтоол, 2023 оны 07 дугаар 04-ны өдрийн 23/16 тоот тогтоолоор Түр орлон гүйцэтгэгч томилох тогтоол, 2023 оны 09 дүгээр 11-ний өдрийн 23/17 тоот тогтоолоор Компанийн Гүйцэтгэх захирал томилох тогтоол, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 558 тоот тогтоол болон, 145-р тоот тогтоолыг дагаж мөрдөх ажлын хүрээнд “Гүйцэтгэх удирдлагын багын журам”-г шинэчлэн батлах, “Бизнес төлөвлөгөө боловсруулах ерөнхий заавар болон процессын зураглал” –г боловсронгуй болгон батлан батлагдсан дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллахыг үүрэг болгон ажиллаа.</p>
7.	<p>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</p>
	<p>Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 558 тоот тогтоол болон, 145-р тоот тогтоолыг дагаж мөрдөх ажлын хүрээнд 2023 оны 09 сард “Эрсдэлийн удирдлагын журам”-г батлан, батлагдсан дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.</p>
<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: А.Энхжаргал</p> <p>Албан тушаал: “Бодь даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p>  <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр: М.Мөнхбаатар</p> <p>Албан тушаал: “Бодь даатгал” ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал</p> <p>Гарын үсэг:.....</p>  <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: Г.Эрдэнэсүвд</p> <p>Албан тушаал: Захиргааны ахлах менежер</p> <p>Гарын үсэг:.....</p> 